



ЗООНОЗЫН ӨВЧНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ЭРГЭН МЭДЭЭЛЭЛ (15)

2019



УЛААНБААТАР, 2020

Ерөнхий редактор

Н.Цогбадрах, Ерөнхий захирал, Анагаах ухааны доктор, Дэд профессор

Хянан тохиолдуулсан

Д.Алтантогтох, ЭШСМТА-ны дарга, Биологийн ухааны магистр, докторант

Эмхэтгэсэн

Х.Бурмаа, Статистикч, НЭМУ магистр, докторант

О.Даариймаа, Статистикч

Мэдээллийг бэлтгэсэн:

1. Д.Ганболд, Нэгдсэн лабораторийн албаны дарга
2. Л.Оргилбаяр, Лавлагаа лабораторийн эрхлэгч
3. Б.Батжав, Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга
4. Э.Нарангарав, Тархвар судлагч
5. Л.Роломжав, Тархвар судлагч
6. Ц.Отгонцэцэг, Тархвар судлагч
7. Ц.Ганхуяг, Шимэгч судлагч
8. Ж.Батцэцэг, Шимэгч судлагч
9. Б.Бямбажав, Нян судлагч
10. У.Өнөрсайхан, Вирус судлагч
11. Х.Тунгалаг, Генетикч
12. Г.Зулцэцэг, Ариутгал, халдваргүйтгэл
13. Б.Хажидмаа, Биоүйлдвэрлэл
14. С.Мөнгөнбагана, Амьтан судлагч
15. П.Алтангэрэл, Сургалтын менежер
16. Ц.Баяр, Амьтан судлаач
17. Ч.Ганцэцэг, Судлаач генетикч
18. Б.Өлзийжаргал, Программ хангамжийн инженер
19. Б.Дарьсүрэн, Сургалтын лаборант

ӨМНӨХ ҮГ

Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төвийн мэргэжилтнүүд, Аймаг, Нийслэлийн Зоонозын Өвчин Судлалын Төвүүдийн мэдээ, тайланд үндэслэн Зоонозын өвчний статистик эмхэтгэлийн 15 дах удаагийн дугаарыг та бүхэнд хүргэж байна.

Дэлхийн цаг уурын өөрчлөлт, дулаарал, даяаршил, аялал жуулчлалын эрчимтэй хөгжилтэй холбоотой дэлхий нийтэд шинэ ба сэргэн тархаж буй халдварт өвчний дэгдэлт гарах нь ихэсч, дэлхий нийтийн тулгамдсан асуудлын нэг болж байна. 1970-аад оноос хойш дэлхий дахинд 300 гаруй байгалийн голомтот болон шинэ ба сэргэн тархаж буй халдварт өвчний дэгдэлт бүртгэгдсэний 70 орчим хувь зоонозын халдварт өвчин байна.

Дэлхий дахиныг хамарсан томуугийн цар тахал, Эбола, Корона, Зика вирүст халдварууд гарч, улс орнуудад эрүүл мэнд, эдийн засгийн асар их хохирол учруулж байгаа бөгөөд 200 гаруй ерөнхий нэршлийн зоонозын халдварт өвчин бүртгэгдсэн байна.

Монгол улсад 30 гаруй зоонозын халдварыг оношилж бүртгэж байгаагаас 10 гаруй өвчин жил бүр бүртгэгдэж байна. 2019 онд зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй 1022, амьтны 143 дуудлага бүртгэгдсэн байна. Сэжигтэй тохиолдлын тоо өнгөрсөн оныхоос 19.3 хувь буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 5.4 хувь өссөн байна. 2019 оны байдлаар зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн сэжигтэй 1022 дуудлага бүртгэгдснээс 183 тохиолдол буюу 18.2 хувь нь батлагдаж 10,000 хүн амд 0.5 байгаа нь өмнөх оноос 44.4 хувь буурсан байна. Нийт батлагдсан тохиолдлын 76 хувь хачигт риккетсиоз, 10 хувь, хачигт энцефалит, 9 хувь хачигт боррелиоз, 2 хувь бэтэг, хумхаа, боом, тарваган тахал 1 хувийг тус тус эзэлж байна.

Салбарын албан ёсны статистик мэдээ тайланд тулгуурлан 2019 оны Зоонозын өвчний эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг олон улсын аргачлалын дагуу тооцон, дүгнэлт, үнэлгээ хийж эмхтгэн гаргасан.

Энэхүү эмхтгэл нь салбарын үндсэн үзүүлэлтүүдийг эмнэлгийн тусламж үйлчилгээ, өвчлөл, нас баралтын шалтгаан тус бүрийг аймаг сумаар нь бүсчлэн тооцож 31 хүснэгт, 49 зураг, газар зүйн байршлаар дүрслэн илэрхийлж та бүхний хүртээл болгож байна.

2020 оны зорилго, зорилтодоо **“Эрүүл мэндийн бүх нийтийн хамралт”-ыг хангах зорилгоор 2020-2025 оны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлөвлөлтийн хүрээг хүн ам зүйн болон өвчлөл, нас баралтын төлөвийг харгалзан боловсруулах үндэслэл** болгон хэрэглэх тоон мэдээлэлээр ханган гэж үзлээ.

Энэхүү эмхэтгэл нь энэ салбарын мэргэжилтэн, судлаач нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажил, зоонозын халдварт өвчнүүдийн хариу арга хэмжээг зохион байгуулахад нотолгоо, шинжлэх ухаанч дүгнэлт гаргахад үндсэн суурь мэдээлэл болгон ашиглагдах ач холбогдолтой.

Энэхүү эмхэтгэлийг хамтран боловсруулсан Зоонозын өвчин судлалын нийт хамт олондоо талархал илэрхийлье.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ, АНАГААХ УХААНЫ ДОКТОР Н.ЦОГБАДРАХ

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	8
БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	10
1.1. Монгол улсын хүн ам.....	10
1.2. Монгол улсын малын тоо	11
1.3. Зоонозын өвчин судлах байгууллагын хүний нөөц	12
БҮЛЭГ 2. ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ МЭДЭЭЛЭЛ	13
2.1. Зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын мэдээлэл	13
2.1.1. Зоонозын халдварт өвчний эрсдэлтэй амьтны дуудлагын мэдээлэл	14
2.2. Зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн мэдээлэл	15
2.3. Тарваган тахал	19
2.3.1 Тарваган тахал өвчний хүний өвчлөлийн мэдээлэл	20
2.3.2 Тарваган тахал өвчний байгалийн голомт	21
2.4. Боом	26
2.4.1. Боом өвчлөлийн мэдээлэл	26
2.4.2. Боомын хүн, малын өвчлөлийн мэдээлэл	27
2.4.3. Боомын хяналтын шинжилгээ	29
2.4.4. Боом өвчний орчны хяналтын шинжилгээ	30
2.5. Хачгаар дамжих халдвар	31
2.5.1. Хачгаар дамжих халдварын тандалт судалгаа	31
2.5.2. Хачгаар дамжих халдварын хүний өвчлөлийн мэдээлэл	31
2.5.3. Хачигт риккетсиоз өвчний хүний өвчлөлийн мэдээлэл.....	31
2.5.3.1. Хачигт риккетсиозын хүний өвчний тархалт (аймгаар).....	32
2.5.3.2. Хачигт энцефалит өвчний хүний өвчлөлийн мэдээлэл	34
2.5.3.3. Хачигт боррелиоз өвчний хүний өвчлөлийн мэдээлэл	36
2.6. Галзуу	38
2.6.1. Мал, амьтны галзуу өвчний мэдээлэл	38
2.6.2. Галзуу өвчний хүний өвчлөлийн мэдээлэл.....	39
2.7. Хумхаа	41
2.8. Урвах тахал /Холер/	42
2.8.1. Урвах тахал өвчний хяналтын шинжилгээ	42
2.8.1. Урвах тахал өвчний хүний өвчлөл	43
2.9. Денге чичрэг.....	44
2.10 Бруцеллез өвчлөлийн мэдээлэл	45

2.11	Шувууны томуу өвчин	46
2.11.1	Шувууны томуу өвчний тохиолдол, тархалт	46
2.11.2	Шувууны томуугийн H5N1 вирусын мэдээлэл	47
БҮЛЭГ 3. ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧИЙ ДАРХЛААЖУУЛАЛТ		48
3.1.	Зоонозын өвчний эсрэг дархлаажуулалт	48
3.1.1.	Тарваган тахлын дархлаажуулалт	48
3.1.2.	Боом өвчний дархлаажуулалт	49
3.1.3.	Хачигт энцефалитын эсрэг дархлаажуулалт	49
3.1.4.	Галзуугийн эсрэг дархлаажуулалт	50
БҮЛЭГ 4. ЛАБОРАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ		51
4.1.	Лабораторийн шинжилгээний ерөнхий үзүүлэлт	51
БҮЛЭГ 5. АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙТГЭЛ, БИОҮЙЛДВЭРЛЭЛ		55
БҮЛЭГ 6. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА.....		58
6.1.	Эрдэм шинжилгээний ажил.....	58
6.2.	Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт	59
6.3.	Цахим хуудасны үйл ажиллагаа	59

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 2015-2019 оны Хүн амын тоог аймгаар илэрхийлсэн үзүүлэлт ..	10
Хүснэгт 2. 2015-2019 оны Монгол улсын малын тоог аймгаар илэрхийлсэн дүн	11
Хүснэгт 3. ЗӨСҮТ болон харьяа байгууллагын хүний нөөцийн тоон үзүүлэлт 2019 он	12
Хүснэгт 4. Зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын тоог харьцуулсан үзүүлэлт (2014 - 2019).....	13
Хүснэгт 5. Нийслэлийн хэмжээнд хүлээн авсан зоонозын халдварт өвчний эрсдэлтэй амьтны дуудлагын 2014-2019 оны харьцуулсан үзүүлэлт	14
Хүснэгт 6. Зоонозын хүний өвчлөлийн харьцуулсан үзүүлэлт (2014-2019 он)	15
Хүснэгт 7. Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн зоонозын өвчний 10,000 хүн амд ноогдох өвчлөлийн түвшинг аймгаар илэрхийлсэн үзүүлэлт	18
Хүснэгт 8. Дэлхийд тарваган тахлын хүний өвчлөлийн тохиолдол, нас баралт 2013-2018.....	19
Хүснэгт 9. Тарваган тахлын хүний өвчлөл, нас баралт, 10,000 хүн амд ногдох өвчлөлийн түвшний тоон үзүүлэлт (2018, 2019 онд).	21
Хүснэгт 10. Тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээний сүүлийн таван жилийн үзүүлэлт	22
Хүснэгт 11. Боомын хүний өвчлөл, нас баралт, 10000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин (2019 он)	29
Хүснэгт 12. Боомын голомтын болон орчны хяналтын шинжилгээний 2014-2019 оны харьцуулсан үзүүлэлт.....	30
Хүснэгт 13. Хачгаар дамжих халдварын тандалт судалгаа (2014-2019)	31
Хүснэгт 14. 2018-2019 оны хачигт риккетсиоз өвчний хүний өвчлөл, нас баралт, 10000 хүн амд ногдох өвчлөлийн түвшний тоон үзүүлэлт	33
Хүснэгт 15. Хачигт энцефалит өвчний хүний өвчлөл, нас баралт, 10000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин (2018-2019).....	35
Хүснэгт 16. Хачигт боррелиоз өвчний хүний өвчлөл, нас баралт, 10,000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин (2018-2019).....	37
Хүснэгт 17. Галзуу өвчний хүний өвчлөл, нас баралт, 10,000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин (2018-2019)	40
Хүснэгт 18. Урвах тахал өвчний хяналтын шинжилгээ (2014-2019).....	42
Хүснэгт 19. Урвах тахал өвчний хүний өвчлөл, нас баралт, 10,000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин (2018-2019)	43
Хүснэгт 20. Денге чичрэг өвчний хүний өвчлөл, нас баралт, 10,000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин (2018-2019)	44

Хүснэгт 21. Бруцеллёз өвчний хүний өвчлөл, нас баралт, 10,000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин (2018-2019)	45
Хүснэгт 22. Шувууны томуугийн H5N1 вирусаар өвчилсөн хүний тохиолдол, нас баралт (2003-2019 он)	46
Хүснэгт 23. Зоонозын өвчний нэр төрөл сорьцын тоо /2019/	52
Хүснэгт 24. Ийлдэс судлал, генетик шинжилгээний хамруулсан сорьцын тоо 2019 он	53
Хүснэгт 25. 2019 оны лабораторийн шинжилгээний дүнгийн тоон үзүүлэлт	54
Хүснэгт 26. Ариутгал халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг өмнөх 5 жилийн дундажтай харьцуулсан байдал	55
Хүснэгт 27. Зарцуулагдсан ариутгал, халдваргүйтгэлийн бодис	56
Хүснэгт 28. 2014-2019 оны биоүйлдвэрлэлийн лабораторид үйлдвэрлэсэн биобэлдмэлийн тоон үзүүлэлт	57
Хүснэгт 29. 2019 онд анагаах ухааны салбарт ажиллагсдын товчоо	58
Хүснэгт 30. ЗӨСҮТ-ээс 2019 онд туурвисан бүтээлийн товчоо	58
Хүснэгт 31. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн сургалт (2019)	59

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Мэрэгч амьтдын дуудлагын тоо, шинжилсэн сорьцын тоо/2015-2019 он/.....	14	
Зураг 2. Зоонозын хүний өвчлөл төрлөөр.....	16	
Зураг 3. Зоонозын хүний өвчлөлийн тоон үзүүлэлт (2000 - 2019 онд).....	16	
Зураг 4. Хүний өвчлөлд өртсөн хүмүүсийн боловсролын байдал.....	17	
Зураг 5. Халдвар авсан зам	Зураг 6. Халдварын эх уурхай.....	17
Зураг 7. Тарваган тахлын сэжигтэй болон батлагдсан тохиолдлын тоог аймагаар илэрхийлсэн үзүүлэлт 2019 онд.....	20	
Зураг 8. Тарваган тахлын хүний өвчлөл (сүүлийн 20 жилийн байдлаар)....	20	
Зураг 9. Тарваган тахлын хяналт шинжилгээнд хамрагдсан аймаг, сумд...	23	
Зураг 10. Тарваган тахлын байгалийн голомтын хяналтын шинжилгээнд хамрагдсан сумд	23	
Зураг 11. Тарваган тахал өвчний байгалийн голомтын шинжилсэн талбай	24	
Зураг 12. Шинжилсэн гадны мэрэгч	Зураг 13. Шинжилсэн мэрэгч	24
Зураг 14.Тарваган тахлын өсгөвөр илрэлт	24	
Зураг 15. Мэрэгчийн нягтшил 1 га тайлбайд	25	
Зураг 16. Тарваган тахлын байгалийн голомтын халдварын аюулын зэрэглэл	25	
Зураг 17. Боомоор өвчилсэн <i>Bacillus anthracis</i> бактерийн тархалт.....	26	
Зураг 18. Боомын хүний өвчлөлийн тохиолдол, нас баралт сэжигтэй дуудлагын тоо (сүүлийн 10 жилийн байдлаар)	27	
Зураг 19. Боомын хүн, малын өвчлөлийн мэдээлэл 2010-2019 он	27	
Зураг 20. Боомын хүн, малын өвчлөлийн тохиолдол сүүлийн 20 жилд.....	28	
Зураг 21. Боомын малын өвчлөлийн байдал аймаг сумдаар.....	28	
Зураг 22. Боомын голомт хяналтын шинжилгээний үзүүлэлт.....	30	
Зураг 23. Боомын голомт болон хяналтын шинжилгээг харьцуулсан үзүүлэлт	30	
Зураг 24. Хачгаар дамжих халдварын хүний өвчлөл (2013-2019).....	31	
Зураг 25. Хачигт риккетсиоз өвчний хүний өвчлөлийн сэжигтэй болон батлагдсан тохиолдол (2012-2019).....	32	
Зураг 26.Хачигт риккетсиоз хүний өвчлөл тархалт, аймгаар.....	32	
Зураг 27. Хачигт энцефалтын сэжигтэй хүний өвчлөлийн өвчлөл батлагдсан тохиолдолын үзүүлэлт	34	
Зураг 28. Хачигт энцефалитын хүний өвчлөл бүртгэгдсэн байршил	34	

Зураг 29. Хачигт боррелиоз өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдол (2014-2019)	36
Зураг 30. 2019 Хачигт боррелиоз хүний өвчлөл тархалт, аймаг сумд.....	36
Зураг 31. Мал, зэрлэг амьтны өвчлөл аймгаар 2019 он	38
Зураг 32. Мал амьтны галзуугийн өвчлөл аймаг сумдаар	38
Зураг 33. Хүний галзуу өвчний эрсдэлд өртсөн байдал	39
Зураг 34. Галзуу өвчний байгалийн голомт, өвчлөл нас баралт 1963-2013 он.	39
Зураг 35. Хумхаа өвчний 2018-2019 оны хүний өвчлөл, нас баралт, 10,000 хүн амд ногдох өвчлөлийн түвшний тоон үзүүлэлт	41
Зураг 36. 2019 онд холерын хяналтын шинжилгээнд цуглуулан шинжилсэн сорьцын мэдээлэл.....	42
Зураг 37. Холерын хяналтын шинжилгээнд дээжилсэн сорьцын тоо /аймгаар/	43
Зураг 38. Шувууны томуу өвчлөлийн дэгдэлтийн байдал.....	46
Зураг 39. Монгол оронд зэрлэг шувуудын дунд томуугийн вирусийн H1N1 хэвшил илэрсэн нуурууд.....	47
Зураг 40. Зоонозын өвчний дархлаажуулалтын хамралтын хувь 2015-2019 он.....	48
Зураг 41. Тарваган тахлын дархлаажуулалт 2010-2019 он	48
Зураг 42. Боомын дархлаажуулалт 2010-2019	49
Зураг 43. Хачигт энцефалитын дархлаажуулалт 2010-2019	49
Зураг 44. Галзуугийн вакцинд хамрагдсан байдал 2010-2019	50
Зураг 45. Зоонозын өвчин судлах байгууллагуудын лабораторийн оношилгоо. 2013-2019 оны лабораторийн шинжилгээний тоон үзүүлэлт	51
Зураг 46. Дээжилсэн сорьц /өвчин тус бүрээр/	53
Зураг 47. ЗӨСТ-үүдэд нийлүүлсэн тэжээлт орчин 2019 он	56
Зураг 48. Мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл, шавжгүйтгэл, халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн газар, тайлбайн хэмжээ	57
Зураг 49. 2017-2019 оны эрдэм шинжилгээний ажлын тоон үзүүлэлт	58

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Монгол улсын хүн ам

2019 оны байдлаар Монгол улсын хүн амын тоо 3,296,866 -д хүрч өмнөх оноос 58,387 хүн буюу 1.8 хувиар өссөн байна. (Хүснэгт 1).

Хүснэгт 1. 2015-2019 оны Хүн амын тоог аймгаар илэрхийлсэн үзүүлэлт

Аймаг	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	3,057,778.	3,119,935.	3,177,899.	3,238,479.	3,296,866
Баруун бүс	390,594.	393,069.	400,703.	408,979.	412,036
Баян-Өлгий	100,189.	100,172.	102,604.	105,090.	108,530
Говь-Алтай	56,209.	56,587.	57,484.	58,471.	57,748
Завхан	69,916.	70,546.	71,551.	72,779.	72,823
Увс	80,763.	81,278.	82,688.	84,309.	83,223
Ховд	83,517.	84,486.	86,376.	88,330.	89,712
Хангайн бүс	577,252.	582,873.	593,645.	604,353.	605,216
Архангай	92,059.	93,135.	95,106.	96,720.	94,994
Баянхонгор	83,936.	84,807.	86,594.	88,356.	88,672
Булган	60,014.	60,603.	61,289.	62,214.	62,089
Орхон	100,731.	101,789.	103,997.	105,987.	107,634
Өвөрхангай	112,353.	113,157.	115,098.	117,112.	116,732
Хөвсгөл	128,159.	129,382.	131,561.	133,964.	135,095
Төвийн бүс	485,525.	492,494.	504,319.	513,438.	516,611
Говьсүмбэр	16,522.	16,926.	17,383.	17,796.	17,928
Дархан-Уул	100,939.	101,876.	104,074.	105,923.	107,018
Дорноговь	65,267.	66,450.	68,147.	69,304.	71,014
Дундговь	44,429.	44,762.	45,755.	46,628.	47,104
Өмнөговь	61,655.	63,307.	65,314.	66,722.	69,187
Сэлэнгэ	106,292.	107,513.	109,605.	111,403.	110,110
Төв	90,421.	91,660.	94,041.	95,662.	94,250
Зүүн бүс	208,119.	211,052.	216,259.	220,334.	223,193
Дорнод	76,476.	77,579.	79,445.	80,984.	82,054
Сүхбаатар	59,034.	59,810.	61,131.	62,322.	63,182
Хэнтий	72,609.	73,663.	75,683.	77,028.	77,957
Улаанбаатар	1,396,288.	1,440,447.	1,462,973.	1,491,375.	1,539,810

1.2. Монгол улсын малын тоо

2019 оны жилийн эцсийн байдлаар малын тоо 70.949.315 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 4.5 сая толгой буюу 6.8 хувиар өссөн байна. Үүнээс адуу 5.9 хувь (4,214,818) үхэр 6.7 хувь (4,753,192), тэмээ 0.7 хувь (472,379), хонь 45.5 хувь (32,267,265), ямаа 41.2 хувь (29,261,661) хувийг эзэлж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. 2015-2019 оны Монгол улсын малын тоог аймгаар илэрхийлсэн дүн

Засаг захиргааны нэгж	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	55,979,781	61,549,236	66,218,959	66,460,180	70,949,315
Баруун бүс	13,711,182	15,135,830	16,201,579	15,557,380	16,004,300
Завхан	3,133,018	3,406,207	3,222,615	3,555,410	3,849,910
Говь-Алтай	2,922,571	3,497,492	3,801,651	3,513,370	3,597,700
Баян-Өлгий	2,021,046	2,167,351	3,597,278	2,166,920	2,192,760
Ховд	2,905,441	3,280,640	3,129,884	3,146,410	3,084,330
Увс	2,729,106	2,784,140	3,446,617	3,175,280	3,279,600
Хангайн бүс	20,481,571	23,163,735	24,404,788	24,323,006	26,246,450
Орхон	119,750	134,204	122,340	114,350	126,950
Өвөрхангай	4,510,986	5,208,582	5,743,53	5,461,350	5,625,460
Булган	3,223,822	3,485,606	3,361,633	3,305,50	3,644,610
Баянхонгор	3,771,867	4,236,321	4,587,74	4,249,470	4,644,870
Архангай	4,457,082	5,009,636	5,297,807	5,482,030	6,167,040
Хөвсгөл	4,398,064	5,089,386	5,297,81	5,710,370	6,040,430
Төвийн бүс	13,206,503	14,154,425	15,193,413	15,428,46	16,958,68
Төв	4,458,608	4,705,866	4,685,13	4,582,440	4,979,160
Говьсүмбэр	379,477	397,910	438,41	427,460	452,000
Сэлэнгэ	1,458,740	1,599,750	1,509,93	1,540,040	1,682,490
Дорноговь	1,801,178	1,752,918	2,001,64	2,148,130	2,404,250
Дархан-Уул	288,363	324,163	310,94	306,010	347,350
Өмнөговь	2,055,765	2,313,963	2,654,39	2,598,440	3,000,300
Дундговь	2,764,372	3,059,855	3,592,98	3,825,940	4,093,120
Зүүн бүс	8,176,870	8,656,917	9,995,535	10,739,50	11,314,99
Дорнод	1,555,425	1,722,910	2,057,808	2,377,780	2,629,620
Сүхбаатар	3,070,254	3,030,437	3,528,41	3,716,810	3,817,010
Хэнтий	3,551,191	3,903,570	4,409,317	4,644,910	4,868,360
Улаанбаатар	403,655	438,329	423,644	411,780	444,890

(Үндэсний статистикийн хороо, 2019)

1.3. Зоонозын өвчин судлах байгууллагын хүний нөөц

2019 оны байдлаар Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төвд 103, харьяа Зоонозын Өвчин Судлалын Төвүүдэд 282 нийтдээ 385 эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон бусад мэргэжилтнүүд ажиллаж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. ЗӨСҮТ болон харьяа байгууллагын хүний нөөцийн тоон үзүүлэлт 2019 он

Үзүүлэлт		М/Д	Архангай	Дундговь	Хэнтий	Өмнөговь	Увс	Говь-Алтай	Нийслэл	Баян-Өлгий	Завхан	Өвөрхангай	Баянхонгор	Сэлэнгэ	Ховд	Хөвсгөл	ЗӨСҮТ
Эмч	Халдвар судлагч	1	1	-	2	1	2	1	2	2	1	1	2	1	1	2	9
	Нян судлагч	2	2	1	1	1	1	1	2	2	1	2	2	1	2	1	7
	Бусад	3	1	1	-	1	1	1		1	1	1	1	-	1	1	7
	Бүгд (1+2+3)	4	4	2	3	3	4	3	4	5	3	4	5	2	4	4	23
Бусад дээд мэргэжилтэн	Амьтан судлагч	5	2	1	1	1	1	1	1	2	1	1	1	1	3	3	4
	Шимэгч судлалын	6	1	0.5	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	5
	Бусад	7	3	0.5	3	1	4	2	5	2	1	-	4	-	3	1	30
	Бүгд (5+6+7)	8	6	2	5	3	6	4	6	5	3	2	6	2	7	5	39
Бүх дээд мэргэжилтэн		9	10	4	8	6	10	7	11	10	6	6	11	4	11	9	62
Лаборант	Нян судлалын	10	1	-	2	1	1	2	1	2	2	1	2	1	2	1	7
	Амьтан судлалын	11	-	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	-	1	0
	Шимэгч судлалын	12	-	-	1	1	1	1	0	1	1	-	1	1	1	1	1
	Бусад	13	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	1	2
Бүгд (10+11+12+13)		14	2	2	4	3	3	4	2	4	4	2	4	3	3	4	9
Бусад мэргэжилтэн	Бага эмч	15	1	-	1	1	1	1	1	1	1	-	1	-	-	1	5
	Сувилагч	16	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
	Ариутгагч, автоклавчин	17	1	1	2	1	2	2	2	2	1	2	2	1	2	3	7
	Голомт хяналтын бага эмч	18	-	-	-	-	-	1	1	3	1	-	3	-	-	-	-
Бусад		19	8	3	11	2	4	6	6	7	5	3	8	5	7	7	20
Бүгд (9+14+15+16+17+18+19)		20	22	10	26	13	20	21	22	27	18	13	29	13	23	25	103
Нийт																	385

БҮЛЭГ 2. ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. Зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын мэдээлэл

Улсын хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар 28 төрлийн 45,232 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 139.7 ногдож байна. Өмнөх оны мөн үеэс 3,158 тохиолдлоор буюу 10,000 хүн амд ногдох өвчлөл 7.3 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс Зоонозын халдварт өвчин 0.6 хувь эзэлж байна.

Монгол улсад 2019 онд Зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй 1,022 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар буурсан, сүүлийн 5 жилийн дунджаас 5.4 хувь өссөн үзүүлэлттэй байна. Хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын тоог өвчнөөр нь харьцуулахад тарваган тахал 0.7 хувь /7/, боом 0.9 хувь /9/, хачигт энцефалит 0.6 хувь /88/, хачигт боррелиоз 7.5 хувь /77/, хачигт риккетсиоз 66.1 хувь /676/, хумхаа 0.5 хувь /5/, галзуугийн сэжигтэй мал, амьтанд уруулж, ноцуулсан 12.9 хувь /132/, денге чичрэг 0.5 хувь /5/, бэтэг 1.8 хувь /18/, бруцеллэз 0.3 хувь /3/, денгийн халуурал 0.5 хувь /5/ ям 0.1 хувь /1/, ку чичрэг 0.1 хувь /1/, токсоплазмоз, татран 0 хувийг эзлэж байна. Үүнээс боом, хачгаар дамжих халдварууд, хумхаа, бэтэг, галзуугийн сэжигтэй мал, амьтанд уруулж ноцуулсан сэжигтэй тохиолдлын тоо өмнөх оноос буурсан байна. Мөн бруцеллэз, денгийн халуурал, ям зэрэг өвчнүүдийн сэжигтэй тохиолдлууд бүртгэгдсэн байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын тоог харьцуулсан үзүүлэлт (2014 - 2019)

Өвчний нэр	2014	2015	2016	2017	2018	2019	2014-2019 он		
							2018-2019	Өмнөх 5 жил дундаж	5 жил дундаж 2019 он
Тарваган тахал	7	9	4	8	7	7	-	7	-
Боом	22	18	13	12	10	9	-10	15	-40
Хачигт энцефалит	43	83	177	230	181	88	-51.3	142.8	-38.3
Хачигт боррелиоз	29	14	94	116	96	77	-19.7	69.8	10.3
Хачигт риккетсиоз	425	368	437	929	822	676	-17.7	596.2	13.3
Хумхаа	3	2	6	4	2	5	150	3.4	47.05
Галзуугийн эрсдэлд өртсөн	85	99	151	169	121	132	9	125	5.6
Денге чичрэг	-	-	2	3	1	5	400	1.2	316.6
Бэтэг	-	-	-	17	25	18	-28	8.5	114.2
Токсоплазмоз	-	-	-	1	1	-	0	0.4	-
Ку чичрэг	-	-	-	-	1	1	-	0.4	60
Татран	-	-	-	-	1	-	0	0.2	-
Бруцеллэз	-	-	-	-	-	3	шинэ	-	-
Ям	-	-	-	-	-	1	шинэ	-	-
Нийт	614	594	884	1489	1267	1022	-19.3	969.6	5.4

2.1.1. Зоонозын халдварт өвчний эрсдэлтэй амьтны дуудлагын мэдээлэл


2019 онд Улсын хэмжээнд нийт зоонозын халдварт өвчний 143 амьтны дуудлагад үйлчлэн ажилласан байна. Үүнээс Дундговь 3, Дорнод 1, Төв аймагт 5, Улаанбаатар 132, тодорхойгүй 2 бүртгэгдсэн байна. Дуудлагын тоо өмнөх оны мөн үеэс 50.5 хувь, материалын тоо 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Мөн энэ оны үзүүлэлтийг 5 жилийн дундажтай харьцуулахад дуудлагын тоо 75.2 хувь, материалын тоо 94.4 хувиар тус тус өссөн байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Нийслэлийн хэмжээнд хүлээн авсан зоонозын халдварт өвчний эрсдэлтэй амьтны дуудлагын 2014-2019 оны харьцуулсан үзүүлэлт

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	5 жилийн дундаж	5 жилийн дундаж, 2019 оны өөрчлөлт	2018 он 2019 оны өөрчлөлт
Дуудлагын тоо	69	88	75	81	95	143	81.6	75.2	50.5
Сорьцын тоо	510	809	382	281	258	871	448	94.4	237.6

Нийт хүлээн авсан дуудлага, шинжилгээнд хамруулсан сорьцын тоог сүүлийн 5 жилээр харьцуулж үзэхэд 2015, 2019 он шинжилсэн сорьцын тоо өндөр үзүүлэлттэй байна (Зураг 1).

Зураг 1. Мэрэгч амьтдын дуудлага, шинжилсэн сорьцын тоо /2015-2019 он/



2.2. Зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн мэдээлэл

2019 оны байдлаар зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн сэжигтэй 1022 дуудлага бүртгэгдсэнээс 183 тохиолдол буюу 18.2 хувь нь батлагдсан байна. Батлагдсан тохиолдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд хачигт боррелиоз 29.1 хувь, хачигт риккетсиоз 31.5 хувь, хачигт энцефалит 40.6 хувь, бэтэг 84 хувиар буурсан үзүүлэлттэй, харин тарваган тахал, боом, хумхаа өвчлөлүүд өссөн үзүүлэлттэй байна. Харин 5 жилийн дундаж үзүүлэлтийг 2019 оны үзүүлэлттэй харьцуулж үзэхэд боом 75 хувь, хачигт энцефалит 50.7 хувь, хачигт боррелиоз 48.8 хувиар буурсан, тарваган тахал, хачигт риккетсиоз, хумхаа, бэтэг өвчин 40-өөс дээш хувиар өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт 6).


Хүснэгт 6. Зоонозын хүний өвчлөлийн харьцуулсан үзүүлэлт (2014-2019 он)

Өвчний нэр	2014	2015	2016	2017	2018	2019	2018, 2019 оны өөрчлөлт хувь	Өмнөх 5 жилийн дундаж үзүүлэлт	2019 оны үзүүлэлт 5 оны өөрчлөлт хувь
Тарваган тахал	1	3	0	1	0	2	200	1	100
Боом	10	7	2	1	0	1	100	4	-75
Хачигт энцефалит	7	40	52	62	32	19	-40.6	38.6	-50.7
Хачигт боррелиоз	1	17	78	46	24	17	-29.1	33.2	-48.8
Хачигт риккетсиоз	269	137	196	357	203	139	-31.5	232.4	40.1
Галзуу	0	0	0	0	0	0	-	0	-
Хумхаа	3	1	3	2	0	1	100	1.8	44.4
Баруун нил	0	1	0	0	0	0	-	0.2	-
Денге чичрэг	0	0	1	0	1	0	-100	0.4	-
Бэтэг	0	0	0	17	25	4	-84	8.4	52.4
Нийт	291	206	332	486	285	183	-35.7	276.2	-33.7

2019 онд бүртгэгдсэн зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн тоон үзүүлэлтээс 76 хувь нь хачигт риккетсиоз, 10 хувь нь хачигт энцефалит, 9 хувь


нь хачигт боррелиоз, 2 хувь нь бэтэг, хумжаа, боом, тарваган тахал тус бүр 1 хувийг эзэлж байна (Зураг 2).

Зураг 2. Зоонозын хүний өвчлөл, төрлөөр




Зоонозын хүний өвчлөлийн тоон үзүүлэлтээс харахад өмнөх оны мөн үеэс 35.7 хувиар /102/, сүүлийн 5 жилийн 320 дунджаас 42.8 хувиар /137/ буурсан үзүүлэлттэй байна (Зураг 3).

Зураг 3. Зоонозын хүний өвчлөлийн тоон үзүүлэлт (2000 - 2019 онд)




Зоонозын өвчлөлөөр өвчилсэн хүмүүсийн боловсролын байдлыг харьцуулж үзэхэд боловсролгүй 19 хувь, бага 8 хувь, бүрэн дунд 16 хувь, боловсролын байдал тодорхойгүй 36 хувийг эзэлж байна. Үүнээс харахад өвчилсэн хүмүүсийн дийлэнх хувь нь бүрэн дундаас доош боловсролтой байна (Зураг 4).

Зураг 4. Хүний өвчлөлд өртсөн хүмүүсийн боловсролын байдал




Нийт зоонозын халдварт өвчний хүний өвчлөлд өртөгсдийн дийлэнх хувь нь дам халдварын байдлаар өвчилсөн ба халдварын эх уурхай нь хачиг байна. (Зураг 5, 6)

Зураг 5. Халдвар авсан зам



Зураг 6. Халдварын эх уурхай



2019 онд бүртгэгдсэн зоонозын өвчний өвчлөлийн түвшин 10,000 хүн амд 0.5 байгаа нь өмнөх оноос 44.4 хувь буурсан байна. Өвчлөлийн түвшинг аймгаар нь харьцуулж үзэхэд хачигт риккетсиоз Говь-Алтай, Хөвсгөл, хачигт энцефалит Сэлэнгэ, хачигт боррелиоз Завхан, бруцеллэз Дорнод, Баянхонгор аймагт тус тус өндөр үзүүлэлттэй байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн зоонозын өвчний 10,000 хүн амд ноогдох өвчлөлийн түвшинг аймгаар илэрхийлсэн үзүүлэлт

№	Аймаг	Тарваган тахал	Боом	Галзуу	Хачигт риккетсиоз	Хачигт энцефалит	Хачигт боррелиоз	Хумхаа	Денге чичрэг	Бруцеллэз
1	Архангай	0	0	0	1.2	0	0	0	0	0.3
2	Баян-Өлгий	0.2	0	0	0.2	0	0	0	0	0
3	Баянхонгор	0	0	0	0.3	0	0	0	0	1.2
4	Булган	0	0	0	0	0.5	0	0	0	0.5
5	Говь-Алтай	0	0	0	3.9	0	0	0	0	0.2
6	Говьсүмбэр	0	0	0	1.1	0	0	0	0	0
7	Дархан-Уул	0	0	0	0	0.1	0	0	0	0
8	Дорноговь	0	0	0	0	0	0	0	0	0.1
9	Дорнод	0	0	0	0.9	0	0	0	0	4.0
10	Дундговь	0	0	0	0	0	0	0	0	0.6
11	Завхан	0	0	0	0.8	0	0.8	0	0	0.3
12	Орхон	0	0.1	0	0.7	0.1	0	0	0	0
13	Өвөрхангай	0	0	0	0.7	0	0	0	0	0.4
14	Өмнөговь	0	0	0	0.3	0	0	0	0	0
15	Сүхбаатар	0	0	0	0	0	0	0	0	0.8
16	Сэлэнгэ	0	0	0	0.1	0.8	0	0	0	0.0
17	Төв	0	0	0	0.3	0	0.4	0	0	0.4
18	Увс	0	0	0	0.2	0	0	0	0	0.8
19	Ховд	0	0	0	0.2	0	0	0	0	0.1
20	Хөвсгөл	0	0	0	2.7	0.1	0	0	0	0.1
21	Хэнтий	0	0	0	0.4	0	0	0	0	0.5
22	Улаанбаатар	0	0	0	0.1	0	0	0	0	0.1
	Улсын дүн	0	0	0	0.4	0.1	0.1	0	0	0.3

2.3. Тарваган тахал

Дэлхий хэмжээнд сүүлийн 6 жилийн байдлаар тарваган тахал өвчний тохиолдол 2,836 тохиолдол бүртгэгдэж, 504 хүн нас барсан байна (Хүснэгт 8). Монгол улсад 2019 оны байдлаар Баян-Өлгий аймагт тарваган тахал өвчний 2 тохиолдол бүртгэгдэж, нас барсан байна.

Хүснэгт 8. Дэлхийд тарваган тахлын хүний өвчлөлийн тохиолдол, нас баралт 2013-2018

Африк тив	2013		2014		2015		2016		2017		2018	
	Тох	Н/Б	Тох	Н/Б	Тох	Н/Б	Тох	Н/Б	Тох	Н/Б	Тох	Н/Б
Конго-Киншаса	55	2	78	12	18	5	116	9	10	2	133	5
Мадагаскар	675	118	482	112	275	63	126	28	661	87	104	34
Уганда	13	3	6	0	0	0	0	0	0	0	0	0
Танзани	0	0	31	1	5	3	0	0	0	0	0	0
Нийт	743	126	597	125	301	71	242	37	671	89	237	39
Америк тив	2013		2014		2015		2016		2017		2018	
Боливи	0	0	2	1	0	0	-	-	-	-	1	1
Перу	24	2	8	1	0	0	1	0	3	0	4	1
Америкийн Нэгдсэн Улс	4	1	10	0	16	4	4	0	5	0	1	0
Нийт	28	3	20	2	16	4	5	0	8	0	6	2
Ази тив	2013		2014		2015		2016		2017		2018	
Хятад	0	0	3	3	0	0	1	0	1	1	0	0
Орос	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0
Кыргызстан	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0
Монгол	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	0
Нийт	1	1	5	3	3	2	1	0	2	0	0	0
Дэлхийд	772	130	622	130	320	77	248	37	681	89	243	41
НИЙТ												

2.3.1 Тарваган тахал өвчний хүний өвчлөлийн мэдээлэл


Монгол улсад 2019 оны байдлаар тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол Баян-Өлгий, Увс, Ховд, Хөвсгөл, Төв аймагт нийт 7 дуудлага бүртгэгдсний Баян-Өлгий аймгийн 2 тохиолдол онош батлагдсан. (Зураг 7).

Зураг 7. Тарваган тахлын сэжигтэй болон батлагдсан тохиолдлын тоог аймгаар илэрхийлсэн үзүүлэлт 2019 онд



Тарваган тахал өвчний сэжигтэй дуудлагыг сараар авч үзвэл 10 сард 57.2 хувь /4/, 7 сард 48.8 хувь /3/ нь бүртгэгдсэн байна. Дуудлагын шалтгааныг авч үзвэл тарвагны мах чанах, боодог хийж идсэн 72 хувь /5/, тарваганд гараа хазуулсан 14.2 хувь /1/, үхсэн тарвагатай харьцсан 14.2 хувь /1/ хүний дуудлага ирүүлсэн байна. 1999-2019 онд нийт тарваган тахлын 73 тохиолдол бүртгэгдэж 26 (CFR 35.6 хувь) нь нас баржээ. Энэ 20 жилд бүртгэгдсэн тарваган тахлын хүний өвчлөлийг өмнөх 20 жилд харьцуулахад ($R^2=0.0217$) буурах хандлагатай байна (Зураг 8).

Зураг 8. Тарваган тахлын хүний өвчлөл (сүүлийн 20 жилийн байдлаар)



2019 онд тарваган тахлын хүний өвчлөл улсын хэмжээнд 10,000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин 0, нас баралтын тоо 2 байна. Харин Баян-Өлгий аймагт 10,000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин 0.2, нас баралт 2 байна. (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Тарваган тахлын хүний өвчлөл, нас баралт, 10,000 хүн амд ногдох өвчлөлийн түвшний тоон үзүүлэлт (2018, 2019 онд).

№	Аймаг	А 20 Тарваган тахал /Plague				Нас баралт
		Өвчлөл		10,000 хүн амд		
		2018	2019	2018	2019	
1	Архангай	0	0	0	0	0
2	Баян-Өлгий	0	2	0	0.2	2
3	Баянхонгор	0	0	0	0	0
4	Булган	0	0	0	0	0
5	Говь-Алтай	0	0	0	0	0
6	Говьсүмбэр	0	0	0	0	0
7	Дархан-Уул	0	0	0	0	0
8	Дорноговь	0	0	0	0	0
9	Дорнод	0	0	0	0	0
10	Дундговь	0	0	0	0	0
11	Завхан	0	0	0	0	0
12	Орхон	0	0	0	0	0
13	Өвөрхангай	0	0	0	0	0
14	Өмнөговь	0	0	0	0	0
15	Сүхбаатар	0	0	0	0	0
16	Сэлэнгэ	0	0	0	0	0
17	Төв	0	0	0	0	0
18	Увс	0	0	0	0	0
19	Ховд	0	0	0	0	0
20	Хөвсгөл	0	0	0	0	0
21	Хэнтий	0	0	0	0	0
Аймгийн дүн		0	2	0	0	2
22	Улаанбаатар	0	0	0	0	0
Улсын дүн		0	2	0	0	2

2.3.2 Тарваган тахал өвчний байгалийн голомт

2019 онд тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээг системийн хэмжээнд 13 аймаг (76.4 хувь)-ийн 40 сум (29.1 хувь) (голомтот газартай харьцуулав) буюу улсын хэмжээнд 19 аймгийн 51 сум, нийслэлийн 7 дүүрэг хамруулан хийсэн байна. Шинжилгээнд нийт 2,230,245 га талбайг

хамруулсан. Үүнээс 292,709 га талбайд гүнзгийрэл, 1,026,836 га талбайд тандалт, 910,700 га талбайд хайгуул шинжилгээг хийсэн

Нийт шинжилгээнд хамрагдалтаас 3,127 мэрэгч туулай хэлбэртэн, 275 зэм үхдэл, 2,432 махчин шувуудын гулгидас, 7,091 гадны шимэгчийг цуглуулан шинжилж байгалийн голомтоос тарваган тахлын өсгөвөр 39, эерэг сорьц 81, листер өвчний үүсгэгч 2-г тус тус илрүүлсэн байна.


Нийт шинжилсэн талбайн сүүлийн 5 жилийн дунджаас 34.8 хувиар, өмнөх оноос 16.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад гүнзгийрэл шинжилгээ 3.1 хувиар, тандалт шинжилгээ 28.7 хувиар, хайгуул шинжилгээний талбай 34.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээний сүүлийн таван жилийн үзүүлэлт


№	Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	Дундаж
1	Аймаг	13	14	14	14	14	19	14.6
2	Сум	46	56	66	65	78	51	60.3
3	Шинжилсэн талбай	1800430	1455095	1743818	1895909	2060472	2230245	186428
4	Гулигдас	2117	1878	1826	2330	2278	2432	2143.5
5	Зэм үхдэл	53	66	76	209	244	275	153.8
6	Шинжилсэн шимэгч	9957	10813	10080	8822	11162	7091	9654
7	Шинжилсэн амьтан	2942	2803	2077	2457	2685	3127	2681.8
8	Илэрсэн өсгөвөр	8	21	4	13	53	39	23
9	Илэрсэн эерэг сорьц	0	15	11	93	73	81	54.6

Төв-Алтайн голомтын Увс, Монгол-Алтай голомтын Баян-Өлгий, болон Хангайн дэрлэгүүн голомтод хамаарах Завхан, Өвөрхангай аймгийн нутгаас тарваган тахлын өсгөвөр илрүүлсэн. Нийт шинжилгээ хийсэн бүс нутгийн 135,000 га нь эпизооттой, 450,000 га нь халдвартай талбай болохыг тогтоолоо. Тарваган тахал өвчний байгалийн голомт хяналтын шинжилгээнд нийт Төв-Алтай, Монгол-Алтай, Хангай, Дундад халх, Хэнтий, Зүүн говь 7 дэрлэгүүний 13 аймаг, нийт 40 сум хамрагдсан байна. Үүнээс Ховд, Хэнтий аймгийн зарим сум тарваган тахлын хяналт шинжилгээнд хамгийн өндөр хамрагдсан байна (Зураг 9. 10).

Зураг 9. Тарваган тахлын хяналт шинжилгээнд хамрагдсан аймаг, сумд




Зураг 10. Тарваган тахлын байгалийн голомтын хяналтын шинжилгээнд хамрагдсан сумд




Монгол улсын хэмжээнд тарваган тахал өвчний агуулагчдын нягтшлыг мэрэгч тус бүрээр авч үзвэл: Монгол тарвага 1 га-д дунджаар 0.9, урт сүүлт зурам 1 га-д 3.7, огдой 1 га-д 5.5, чичүүл 6.6 тус тус ногдож байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад тарвага, зурамны нягтшил адил харин чичүүл 6.1 хувиар, огдой 2.8 хувиар тус тус өссөн байна. Харин дамжуулагчдын хувьд: Мэрэгчийн үс ноолуурт ноогдоц-2.4, тохиолдоц 38.6 хувь, нүхний амсарт ноогдоц-0.03, тохиолдоц 9 хувь, ноохойн ноогдоц 13.2, тохиолдоц 84 хувьтай байна. Тарваган тахал өвчнийг дамжуулахад чухал үүрэг гүйцэтгэгч бүүрэгний ерөнхий нөөц тарваганд 14.6, урт сүүлт зураманд 11.7, чичүүлд 46.9, үлийн цагаан оготонод 6.4 тус тус байгаа нь дамжуулагчийн нөөц хэвийн түвшинд байна (Зураг 12).

Зураг 11. Тарваган тахал өвчний байгалийн голомтын шинжилсэн талбай




Сүүлийн жилүүдэд Монгол-Алтай, Хангай, Дундад халхын тарваган тахлын байгалийн голомтод тахлын эпизоот өндөр идэвхтэй явагдаж байна. Тарваган тахлын байгалийн голомтын идэвхжил нь мэрэгчдийн нягтшил, халдвар дамжуулах идэвхтэй бүүрэгний тоошилтой шууд хамаардаг бөгөөд цаашид жижиг мэрэгчдийн дунд тахлын эпизоот хүрээгээ тэлэх хандлагатай байна. Тарваган тахлын өсгөвөр илрэлт болон хүний өвчлөлийн тохиолдлын тоо хоорондоо шууд хамааралтай ($r=0.99$) (Зураг 12, 13).

Зураг 12. Шинжилсэн гадны мэрэгч




Зураг 13. Шинжилсэн мэрэгч




Илрүүлсэн тахлын өсгөврийн тоо өмнөх оноос 4.6 дахин, илэрсэн эерэг сорьцын тоо 1.9 дахин өссөн. Тарваган тахал өвчний өсгөврийн 83.8 хувь нь тарвага болон түүний зэм үхдэлээс, 10.8 хувь нь гадны шимэгчээс, 5.4 хувь нь бусад жижиг мэрэгчид (үлийн цагаан огтоно, бор харх, зурам, огдой, гэрийн хулгана)-аас тус тус илэрсэн байна (Зураг 14).

Зураг 14.Тарваган тахлын өсгөвөр илрэлт



Монгол тарваганы тархалт нь газар нутаг бүр харилцан адилгүй алаг цоог тархалттай бөгөөд Хөвсгөл, Увс, Ховд, Баянхонгор аймгуудын зарим суманд тоо толгой нь өсөх хандлага ажиглагдаж байна. Харин тарваган тахлын дэд агуулагч жижиг мэрэгчийн тархалтын хувьд Монгол орны ихэнх нутаг дэвсгэрт үлийн цагаан оготны нягтшил харьцангуй ихсэж тоо толгой нь нэмэгдэж цаашид эпизоотыг дамжуулахад голлох үүргийг гүйцэтгэх хандлагатай байна. Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Дорноговь аймгийн 8 сумдын нутгаас тарваган тахлын өсгөвөр 60, эерэг сорьц 185 илэрч эпизооттой талбай 385,603 га, халдвартай талбай 415,409 га байгааг тогтоолоо (Зураг 15).


Зураг 15. Мэрэгчийн нягтшил 1 га тайлбайд



Тарваган тахлын байгалийн голомтын шинжилгээнд нийт 6 дэрлэгүүн, 15 аймаг, 79 сум хамрагдсан байна. Үүнээс А зэрэглэлд 25 сум, В зэрэглэлд 27, С зэрэглэлд 27 сум тус тус хамаарсан байна. Үүнээс Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Архангай зэрэг аймагт аюулын зэрэглэл өндөр байна (Зураг 16).

Зураг 16. Тарваган тахлын байгалийн голомтын халдварын аюулын зэрэглэл

(2019 онд)




2.4. Боом

2.4.1. Боом өвчлөлийн мэдээлэл


Дэлхийн хэмжээнд боом өвчнийг үүсгэгч *Bacillus anthracis* бактерийн тархалтыг газрын зураг дээрээс харахад зарим газар өвчлөл бүртгэгдэх магадлалтай байна (Зураг 17).

Зураг 17. Боомоор өвчилсөн *Bacillus anthracis* бактерийн тархалт



2019 онд монгол улсад боомын хүний өвчлөлийн сэжигтэй дуудлага Дорноговь, Баянхонгор, Дорнод аймгийн Баян-Уул, Хэрлэн, Баяндун сум, Орхон, Завхан, Ховд аймгийн Мөст, Буянт сумаас нийт 9 тохиолдол бүртгэгдэж лабораторийн шинжилгээ, тархвар судлалаар Орхон аймгийн Баян-Өндөр суманд боомын хүний өвчлөлийн 1 тохиолдол батлагдсан. Сүүлийн 5 жилд боомын хүний өвчлөлийн тохиолдол жилд 1-2 тохиолдол бүртгэгдэж өвчлөл буурсан үзүүлэлттэй байна (Зураг 18).


Зураг 18. Боомын хүний өвчлөлийн тохиолдол, нас баралт сэжигтэй дуудлагын тоо (сүүлийн 10 жилийн байдлаар)



2.4.2. Боомын хүн, малын өвчлөлийн мэдээлэл

2019 онд боомын малын өвчлөлийн тохиолдол 44 мал бүртгэгдсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 100 хувиар /22/ өссөн, 5 жилийн дунджаас 59.9 хувиар /109.8/ буурсан үзүүлэлттэй байна. Боомын хүний өвчлөлийн тохиолдол өмнөх онд бүртгэгдээгүй бол энэ онд 1 бүртгэгдсэн байна (Зураг 19).

Зураг 19. Боомын хүн, малын өвчлөлийн мэдээлэл 2010-2019 он




Боомын хүн, малын өвчлөлийн тохиолдлыг сүүлийн 20 жилийн байдлаар харьцуулахад харилцан адилгүй өссөн буурсан үзүүлэлттэй байна. Мөн сүүлийн 5 жилийн байдлаар хүн, малын өвчлөлийн тохиолдол буурсан үзүүлэлттэй байна (Зураг 20).

Зураг 20. Боомын хүн, малын өвчлөлийн тохиолдол сүүлийн 20 жилд



Малын боомын өвчлөлийн тохиолдол 2019 онд Булган аймгийн Бугат, Дорнод аймгийн Баян-Дун, Хөвсгөл Цагаан-Үүр, Увс Зүүн-говь, Түргэн суманд тус тус бүртгэгдэж 27 мал боом өвчнөөр өвчилж хорогдсон байна (Зураг 21).

Зураг 21. Боомын малын өвчлөлийн байдал аймаг сумдаар



2019 оны байдлаар боомын хүний өвчлөлийн түвшин 10,000 хүн амд 0, нас баралтын түвшин 0 байна (Хүснэгт 11).


Хүснэгт 11. Боомын хүний өвчлөл, нас баралт, 10000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин (2019 он)

№	Аймаг	А 22 Боом өвчин /Anthrax				Нас баралт
		Өвчлөл		10,000 хүн амд		
		2018	2019	2018	2019	
1	Архангай	0	0	0	0	0
2	Баян-Өлгий	0	0	0	0	0
3	Баянхонгор	0	0	0	0	0
4	Булган	0	0	0	0	0
5	Говь-Алтай	0	0	0	0	0
6	Говьсүмбэр	0	0	0	0	0
7	Дархан-Уул	0	0	0	0	0
8	Дорноговь	0	0	0	0	0
9	Дорнод	0	0	0	0	0
10	Дундговь	0	0	0	0	0
11	Завхан	0	0	0	0	0
12	Орхон	0	1	0	0	0
13	Өвөрхангай	0	0	0	0	0
14	Өмнөговь	0	0	0	0	0
15	Сүхбаатар	0	0	0	0	0
16	Сэлэнгэ	0	0	0	0	0
17	Төв	0	0	0	0	0
18	Увс	0	0	0	0	0
19	Ховд	0	0	0	0	0
20	Хөвсгөл	0	0	0	0	0
21	Хэнтий	0	0	0	0	0
22	Улаанбаатар	0	0	0	0	0
Улсын дүн		0	1	0	0	0

2.4.3. Боомын хяналтын шинжилгээ

Улсын хэмжээнд 2019 оны байдлаар боомын эрсдэлтэй объектод 9 аймаг, нийслэл ЗӨСТ, ЗӨСҮТ Улаанбаатар хотод хяналт шинжилгээ хийж нийт 4,603 нэгж материалыг нян судлал, биологийн аргуудаар шинжилсэн. Үүнээс арчдас 75 хувь /3,300/, арьс шир 4 хувь /152/, үс ноос 4 хувь /195/, хөрс 6 хувь /262/, бууц 5 хувь /218/, сэг зэм 0.04 хувь /2/, бусад 6 хувийг /272/ шинжилсэн байна. Хяналтын шинжилгээгээр боомын үүсгэгч илрээгүй. Боом өвчний голомтын хяналтын шинжилгээг 10 аймгийн 28 суманд гүйцэтгэж нийт 1,766 нэгж материал цуглуулан шинжилснээс хөрс 76 хувь 1,337, бууц 3 хувь /43/, арьс шир 6 хувь /98/, үс ноос 6 хувь /198/, бусад 0.0003 хувь /6/, сэг зэм 3 хувийг /24/ шинжилсэн байна (Зураг 22).

Зураг 22. Боомын голомт, хяналтын шинжилгээний үзүүлэлт



Нийт боомын голомтын шинжилгээ өмнөх оноос 15.7 хувиар буурсан, хяналтын шинжилгээ 10.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. (Зураг 23).

Зураг 23. Боомын голомт болон хяналтын шинжилгээг харьцуулсан үзүүлэлт



2.4.4. Боом өвчний орчны хяналтын шинжилгээ

2019 онд боомын голомтын хяналтын шинжилгээ 1,766 орчны хяналтын шинжилгээ 4,603 нийт 6,369 шинжилгээнд хамрагдсанаас боомын тохиолдол бүртгэгдээгүй байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Боомын голомтын болон орчны хяналтын шинжилгээний 2014-2019 оны харьцуулсан үзүүлэлт

№	Он, шинжилсэн нэгжийн тоо	2014	2015	2016	2017	2018	Сүүлийн 5жил дундаж	2019
1	Боомын голомт хяналтын шинжилгээ	1776	1680	2290	1872	2096	1942	1766
2	Боомын хяналтын шинжилгээ	3760	3702	3639	3799	4155	3811	4603
3	Боомын голомт, хяналтын шинжилгээ (нэгдсэн дүн)	5536	5382	5929	5671	6251	5753	6369
4	Илэрсэн өсгөврийн тоо	8	2	3	0	1	2.8	0

2.5. Хачгаар дамжих халдвар

2.5.1. Хачгаар дамжих халдварын тандалт судалгаа

2019 онд 13 аймгийн 46 сумын 210 цэгт газраас 5,272 сорьц цуглуулсан байна. Цуглуулсан хачгийн тоог өмнөх онтой харьцуулахад 60.8 хувиар, 5 жилийн дунджаас 44.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна (Хүснэгт 13).


Хүснэгт 13. Хачгаар дамжих халдварын тандалт судалгаа (2014-2019)

